

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
NATIONAL STATISTICAL OFFICE OF MONGOLIA



СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬ
MONTHLY BULLETIN OF STATISTICS

12 сар
2009
December

Улаанбаатар хот
Ulaanbaatar

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл
Аргачлалын тайлбар
Товч танилцуулга
Үндсэн үзүүлэлтүүд
I. Хүн ам
II. Хөдөлмөр
III. Нийгмийн зарим үзүүлэлтүүд
IV. Нийгмийн халамж, даатгал
V. Боловсрол
VI. Эрүүл мэнд
VII. Гэмт хэрэг
VIII. Дотоодын нийт бүтээгдэхүүн
IX. Үнэ
X. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл
XI. Улсын нэгдсэн төсөв
XII. Гадаад худалдаа
XIII. Бизнес регистрийн сан
XIV. Хөдөө аж ахуй
XV. Аж үйлдвэр
XVI. Их барилга
XVII. Дотоод худалдаа
XVIII. Тээвэр, холбоо
XIX. Хилээр нэвтэрсэн зорчигчид
XX. Цаг уур, агаарын бохирдолт
Хавсралт

CONTENTS

<i>General notes</i>	3
<i>Methodological notes</i>	4
<i>Introduction</i>	10
<i>Main indicators</i>	18
<i>Population</i>	19
<i>Labour</i>	21
<i>Selected social indicators</i>	25
<i>Social welfare and social insurance</i>	27
<i>Education</i>	29
<i>Health</i>	36
<i>Crime</i>	41
<i>Gross domestic products</i>	45
<i>Price</i>	50
<i>Money, loan, stock market</i>	63
<i>State budget</i>	70
<i>External trade</i>	74
<i>Business Register</i>	86
<i>Agriculture</i>	92
<i>Industry</i>	113
<i>Construction</i>	119
<i>Domestic trade</i>	122
<i>Transport and communications</i>	123
<i>Inbound and Outbound passengers</i>	126
<i>Meteorology and air pollution</i>	128
<i>Appendix</i>	130

Ерөнхий тэмдэглэл**General notes****I. Товчилсон тэмдэглэгээ:**

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГО	Говь-Алтай
ДО	Дорноговь
ДД	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
ДА	Дархан-Уул
УБ	Улаанбаатар
ОР	Орхон
ГС	Говьсүмбэр

I. Abbreviations:

AR	Arkhangai
BO	Bayan-Olgii
BKH	Bayankhongor
BU	Bulgan
GO	Govi-Altai
DO	Dornogovi
DD	Dornod
DU	Dundgovi
ZA	Zavkhan
OV	Ovorkhangai
OM	Omnogovi
SU	Sukhbaatar
SE	Selenge
TO	Tov
UV	Uvs
KHO	Khovd
KHS	Khovsgol
KHE	Khentii
DA	Darkhan-Uul
UB	Ulaanbaatar
OR	Orkhon
GS	Govisumber

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... г.м)

I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

1990-1995; 1990-1997 тухайн хугацааны жилийн дундаж үзүүлэлт болно.

III. Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:

- ... мэдээлэл байхгүй
- 0.0** маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй.

⌌ “Үүнээс” гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

II. Months have been shown by the Roman numerals (I, II, III, IV, V, etc).

I-XII shows the accumulated data from the beginning of the year including the particular month.

1990-1995; 1990-1997 annual average for this particular time period.

III. The following symbols were used:

- ... data are not available
- 0.0** the amount is nil or negligible
- no execution.

⌌ Shows the term “of which” and in some cases it indicates not all elements of sum are given.

IV. Due to the rounding figures (composition) may not add up to the total and 100 percentage.

Аргачлалын тайлбар**Methodological notes****Хөдөлмөр****Labour**

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)"-д Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилна.

Ажилгүй иргэнд тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хамруулна.

The economically active population (Labor Force) comprising all persons of either sex who furnish the supply of labour for the production of economic goods and services (employed and unemployed, including those seeking work), as defined by the System of National Accounts (SNA), during a specified time reference period. Economically active population is divided into "usually active" or "currently active" during a specified time-reference period.

Unemployed is a citizen of labour age, with full work abilities, who was for a while unemployed, ready to work and actively looking for a job.

Боловсрол**Education**

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, төгсөгчид, элсэгчид, багш нарын тоог аймаг, нийслэл, хүйсээр, хичээлийн жилээр гаргав.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль (ЕБС), мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, их, дээд сургууль, коллежид суралцагчид, төгсөгчдийн тоог Боловсролын олон улсын стандарт ангилалын дагуу гаргасан. Боловсролын олон улсын стандарт ангилал нь 1997 онд шинэчлэгдэн мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг ангиллаар боловсролыг 0-6 түвшинд ангилна.

Data for school enrollment, graduates and new entrants is shown by aimags and capital city, sex and academic years.

Such as the number of pupils and students kindergartens, secondary and high school, vocational training institutions and higher educational institutions and universities is being compiled according to the international standard Classification of Education. The ISCED has been updated and revised in 1997 and adopted since then. According to this classification the education is classified between 0-6 levels.

Эрүүл мэнд**Health**

Эрүүл мэндийн сарын мэдээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар аймаг нийслэлийн харъяа нэгжүүдээсээ авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд (ҮСХ)-нд ирүүлдэг.

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд ногдох), 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд

Monthly health statistics are compiled through local units of Health Department, an Implementing Agency of the Government of Mongolia and received by the NSO of Mongolia.

The mortality rate /infant mortality rate/ among children up to 1 year old in every 1000 live birth, child mortality rate aged

төрөлтөд ногдох), халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, өвчний ангиллаар, эмчлүүлсэн болон нас барсан хүний тоог бүсээр гаргаж тооцож оруулсан болно.

Нялхсын эндэгдэл (1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох)-ыг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох)-ыг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

between 1-5 years old in every 1000 live births, a number of people infected by contagious disease, a classification of diseases, and a number of cured people and deaths are calculated by regions.

The infant mortality rate (infants under age one year per 1000 live births) is estimated as a ratio of the number of deaths of infants under 1 year to the number of alive births during a particular period of time.

The under 1-5 mortality rate (under 1-5 age one year per 1000 live births) is estimated as a ratio of the number of deaths of under 1-5 year to the number of alive births during a particular period time.

Гэмт хэрэг

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нэлээд өөрчлөгдсөн.

-Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

-Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

-Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

-Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

-Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

Crime

The Crime indicators have been innovated and enriched in connection with change of Criminal Law.

- Indicators like crime against human life, health, crime to cause others to commit suicide, violent crime such as attempted and negligent murder are being compiled in the bulletin;

- Rape crime was included to the crime against children, family and social morality;

- Crime against ownership right includes theft of property, robbery, snatch away others property, deceiving to obtain others property, illegally misuse others property and wasting;

- Arson was included to crime against environmental protection.

- Indecent assault was added to crime against social safety.

The number of committed offences per 10000 population aged 18 and over is a quotient of the number of crimes and number of people aged 18 and over at the beginning of the year.

Дотоодын нийт бүтээгдэхүүн**Gross domestic product**

Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) анхдагч мэдээллийн эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын албан ёсны мэдээ, тайлан тэнцэл юм.

The primary data sources for Gross Domestic Product (GDP) are official statistics and balancesheets of enterprises.

ДНБ гэдэг нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тухайн хугацаанд дотоод, гадаадын эдийн засгийн харъяатуудын (аж ахуйн нэгж, байгууллага, иргэд) шинээр бий болгосон нэмэгдэл өртөг буюу эцсийн бүтээгдэхүүний нийлбэр юм.

Gross Domestic Product is a sum of value added produced by all domestic and foreign units resident in the economy or sum of final products during one year period.

ҮСГ-ын дарга, Сангийн сайдын 2007 оны 101/203 тоот тушаалаар "Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлого тооцох аргачлал" шинэчлэгдэн батлагдаж, ДНБ-ий 2000-2006 оны тооцоо /динамик/-г дээрх аргачлалын дагуу засварлан тооцлоо.

"Methodology on estimation of GDP and GNI" is approved by a decree Chairman of NSO and Minister of Finance, 101/203, on 2007. GDP from 2000-2006 estimated by this methodology.

Мөн түүнчлэн Статистикийн тухай Монгол улсын хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 22 дугаар заалтын дагуу ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн 2000 оны суурийг 2005 оныхоор шилжүүлэхээр тогтоосон болно.

According to 22nd paragraph of the third part, 12th article of the Law on Statistics, it has decided to change base year of GDP estimation at the constant price from 2000 by 2005.

Үнэ**Prices**

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

The consumer price index is a weighted average by consumption expenditure distribution of prices of various goods and services purchased by the households for its own consumption.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2005 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

Since January 2008 having revised its methodology for CPI by which CPI for Ulaanbaatar city was taken a national CPI, the National Statistics Committee has moved to the international methodology by which the national CPI is estimated on the basis of weighted average for 2005 HIES consumption expenditure of aimags and the Capital city.

Аймгийн төв, нийслэлийн захуудад борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

The average market prices of agricultural foodstuff, wool, hide & skin at aimags centers & the capital city were shown.

Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд банкнаас гадуурх мөнгө, банкны касс дахь бэлэн мөнгийг оруулна.

Мөнгө М1-д улсын болон хувийн секторын харилцах дансан дахь мөнгө, иргэдийн хугацаагүй хадгаламж, банкны гадуурх бэлэн мөнгийг хамруулна.

Мөнгө М2 бол Мөнгө М1 болон бараг мөнгөний нийлбэр юм. Бараг мөнгөнд иргэд, байгууллагуудын хугацаатай хадгаламжууд, гадаад валютын хадгаламжийг хамруулна.

Үнэт цаасны тухайн сарын арилжаанд хамгийн их гүйлгээтэй байсан компанийн хувьцааг идэвхтэй хувьцаа гэж үздэг.

Монгол Улсын нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Сангийн яам, аймаг, нийслэлийн харъяа нэгжүүдээсээ авч нэгтгэн Үндэсний Статистикийн хороо (ҮСХ)-нд ирүүлдэг.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын дүнд Засгийн газрын тусгай зориулалтын гэж нэрлэдэг Тэтгэврийн, Нийгмийн халамжийн, Замын, Өмч хувьчлалын сангуудын орлого, зарлагыг оруулсан.

Гадаад худалдаа

ҮСХ-ны дарга, Сангийн сайд, Гаалийн Ерөнхий Газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хамтарсан тушаалаар “Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг шинэчлэн баталж мөрдүүлсэн.

Money, loan, stock market

Currency in circulation includes the population and commercial banks cash and currency outside the banks.

Money M1 includes public and private sector's bank account currency, population demand deposits and currency outside the banks.

Money M2 is a sum of money M1 and Quasi money. Quasi money consists of the time saving deposits of individuals and enterprises as well as foreign currency deposits.

An active stock in a particular month is considered as the stock of companies with predominated trading.

General government budget

Since October 1995, the budget revenue and expenditure has been compiled according to the International Monetary Fund standard classifications.

The Mongolian General government budget revenue and expenditure consists of the central and local budget revenue and expenditure.

The Ministry of Finance collect and aggregate the General government budget revenue and expenditure data from it's department and offices that are under the jurisdiction of the ministry and forward the data to the National Statistical Office (NSO).

State budget revenue and expenditure includes revenue and expenditure of Government Special funds for Pension, Social Security, Roads, and Privatization.

External trade

On 17th February of 2009, the chairman of NSO, the Minister of Finance and the director of Customs General Administration approved "Methodology of calculating indicators of merchandise trade statistics". According to this new methodology

Шинэчлэгдсэн аргачлалын дагуу гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг тооцож байна. Мөн өмнөх оны гүйцэтгэлүүдийг шинэчилсэн аргачлалын дагуу тооцлоо.

and its amendments, estimates of previous years have changed.

Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын статистикийн мэдээг үндэслэн тус бүлгийн хүснэгтүүдийг боловсруулав.

The table of this chapter were developed on the basis of the statistical reports from the Customs General Administration of Mongolia.

Дэлхийн худалдааны байгууллагаас боловсруулсан “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг авсан болно. С.И.Ф нөхцлийн үнээр импортын барааг үнэлэх бөгөөд энэ нь худалдан авагч орны хил хүртэлх тээвэр болон даатгалын, гаалийн хураамж зэрэг зардлуудыг экспортлогч хариуцна гэсэн үг.

The commodities were classified according to the Harmonized System developed by the World Trade Organization. The price of import goods is defined by the CIF condition which means that exporter has to bear costs of transportation and insurance till purchaser's country border as well as customs tax.

Аж ахуйн нэгжийн регистрийн сан

Business Register

Аж ахуйн нэгжийн регистрийн мэдээллийн санг 1998 онд явагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын үрдүнд тулгуурлан анх байгуулсан бөгөөд түүнээс хойш орсон өөрчлөлтийг Монгол Улсын Татварын Ерөнхий газрын бүртгэл болон бусад байгууллагын мэдээллийг үндэслэн улирал тутам шинэчилж тусган ирсэн болно.

Business Register Database has now been under construction for number of years and is based on the results of the Census of Establishments, which was held in 1998. The Business database is currently updated on regular basis from National General Taxation Department data files as well as other registering organizations.

Энэхүү бүлэгт харуулсан үзүүлэлтүүдийг Үндэсний статистикийн газрын бизнесийн регистрийн сангийн 2005 оны 3-р сарын эцсийн мэдээллээр бэлтгэв.

This Chapter is prepared based on Business Register data of the National Statistical Office, by end of March 2005.

“Хуулийн этгээд” гэж “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 1.1-д заасан зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ.

“Legal Unit” is the organizational structure specified in provision 1.1, article 3 of Law on “State registration of Legal Units” of Mongolia.

Эдийн засгийн хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын хувьд үндсэн үйл ажиллагаагаар ангилан холбогдох салбарт оруулсан болно.

Legal units and economic entities that conduct several economic activities are reported by the main type of business activities.

Аж үйлдвэр

Industry

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын

Classification by the kind of economic activities is based on the ISIC (International

эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Standard Industrial Classification) of United Nation.

The value of total industrial sale is value of sales, completed work and services of business entities during the particular period.

The growth of the industrial production was estimated on the basis of constant price of 2005 for the main commodities.

Data on production of the main industrial commodities shows a physical quantity of the particular produced goods.

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол, гамшгийн хувьд “Гамшгаас хамгаалах тухай” Монгол улсын хуульд заасан ойлголт, тодорхойлолтыг баримталж байна.

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно.

Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Hazardous phenomena and disasters

For terms, namely hazardous phenomena, disasters, and accidents, concepts and definitions set out in the Law on Disaster Protection of Mongolia are followed.

Disasters mean loss of many human lives and livestock, immense damage to property and environment that exceeds national and local resources and capacity due to hazardous phenomena, major technological accidents, and terrorist acts or explosion.

Hazardous phenomena mean severe snow, dust storm, drought, dzud, flood, earthquake, desertification, fire, epidemic, epizootic, hazardous vegetative diseases or spreading detrimental rodents.

Major technological accidents mean destruction of factories, buildings, communication or roads, accidents of transportation facilities or leakage of radioactive and hazardous chemical substances caused by violation of technological procedures.

**Монгол улсын нийгэм,
эдийн засгийн байдал**
(2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр)

**Social and economic situation
of Mongolia**
(As of the preliminary result of 2009)

I. Нийгмийн үзүүлэлт

Монгол улсын хүн амын тоо 2009 оны урьдчилсан дүнгээр 2736.8 мянга болж, өмнөх оныхоос 53.2 мянган хүн буюу 1.98 хувиар өслөө. Эрүүл мэндийн яамны мэдээгээр 2009 онд 1000 хүн амд ногдох төрөлт 25.1, нас баралт 5.7, хүн амын цэвэр өсөлт 19.4 байна.

Улсын хэмжээгээр 2009 онд 68544 эх амаржиж, өмнөх оныхоос 5457 эхээр буюу 8.6 хувь, 68762 хүүхэд амьд төрж, 5500 хүүхдээр буюу 8.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Нэг хүртэлх насандаа 1386 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 146 хүүхдээр, эхийн эндэгдэл 56 болж, 25 эхээр тус тус нэмэгдсэн бол бол 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 240 болж өмнөх оны түвшинд байна.

Ажиллах хүчний судалгааны 2009 оны 3 дугаар улирлын дүнгээр нийт 119.0 мянган ажилгүй иргэд байна. Аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (ХХҮХ)-т бүртгүүлсэн, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2009 оны 12 дугаар сарын эцэст 38.1 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 8264 хүнээр буюу 27.7 хувиар өсчээ. Ажилгүйдлийн энэхүү өсөлтөнд өмнөх оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо Төв (431 хүн), Өвөрхангай (453 хүн), Дархан-Уул (482 хүн), Ховд (483 хүн), Баянхонгор (696 хүн), Завхан (699 хүн), Увс (848 хүн), Булган (1827 хүн) аймгийн болон Улаанбаатар хотод (1350 хүн) нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Бүх шатны сургуульд суралцагчдын тоо (гадаадад суралцагчид, ЕБС-д орой, эчнээгээр суралцагчид ороогүй) 2009/2010 оны хичээлийн жилийн эхэнд 841.1 мянга байгаа нь 2008/2009 оны хичээлийн жилийнхээс 20.7 мянга буюу 2.4 хувиар буурлаа.

I. Social indicators

There is forecast, that Mongolian population reach 2736.8 thousand, this has increased by 53.2 thousand person or 1.98 percent compared with the 2008 year. By data sources of the Ministry of Health, in 2009, births per 1000 population was 25.1, mortality per 1000 population was 5.7 and natural increase per 1000 population was 19.4.

As of the 2009, the number of births (live birth) reached 68544 and it shows an increase of 5457 or 8.6 percent compared to the previous year at national level. The number of mothers delivered children was 68762 and it has an increase of 5500 or 8.7 percent compared with the previous year.

The number of infant mortality reached 1386 and it increased by 146 infants and the number of maternal deaths was 56 and increased by 25, while the number of under-five mortality shows 240 at the same level compared with the previous year.

As results of LFS, for 3rd quarter of 2009, the number of unemployed was 119.0 thous, out of them, a number of unemployed who had registered at Labour and Welfare Service Divisions in aimags and the capital city and were actively looking for job reached 38.1 thous at the end of December 2009. It shows an increase of 8264 or 27.7 percent compared with the same period of the previous year. Such increase of registered unemployed was mainly due to increase of unemployed who had registered in some aimags, namely Tuv (431 persons), Uvurkhongai (453 persons), Darkhan-uul (482 persons), Khovd (483 persons), Bayankhongor (696 persons), Zavkhan (699 persons), Uvs (848 persons), Bulgan (1827 persons), and Ulaanbaatar city (1350 persons), respectively.

At the beginning of academic school year 2009-2010 number of students and pupils in educational institutions in all types reached (excluded students studying abroad and pupils studying in schools with evening classes) 841.1 thousand and decreased by 20.7 thousand or 2.4 percent compared with previous year.

Нийт суралцагчдын 52.1 хувийг эмэгтэй суралцагчид эзэлж байгаа бөгөөд цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхдийн 50.3 хувь, ЕБС-д сурч байгаа хүүхдийн 50.3 хувь, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын 47.0 хувь, их, дээд сургууль, коллежид суралцагчдын 60.4 хувь нь тус тус эмэгтэй суралцагчид байна.

Нийгмийн даатгалд 2009 онд 556.6 мян.хүн хамрагдаж, шимтгэл төлж байгаагийн 352.1 мян.хүн буюу 63.3 хувь нь аж ахуйн нэгжийн, 204.5 мян.хүн буюу 36.7 хувь нь төсөвт байгууллагын даатгуулагчид байна.

Нийгмийн даатгалын сангаас 2009 онд нийт 333.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосны 72.0 хувийг өндөр насны, 13.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 8.0 хувийг тэжээгчээ алдсаны, 6.6 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 2009 онд 1.4 сая хүнд олгож, 120.1 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оныхоос тэтгэвэр, тэтгэмж, тусламж авагчдын тоо 7.5 мян.хүн буюу 0.6 хувь, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 5.4 тэрбум төг буюу 4.7 хувиар тус тус нэмэгджээ.

Халдварт өвчнөөр 2009 онд 38.9 мянган хүн өвчилж, өмнөх оныхоос 4934 хүн буюу 11.3 хувиар буурчээ. Халдварт өвчний өвчлөлийн бууралтад цусан суулгаар өвчлөгчдийн тоо 746 хүн буюу 31.7 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 209 хүн буюу 3.4 хувиар тус тус өссөн хэдий ч вируст хепатитаар өвчлөгчдийн тоо 3539 хүн буюу 34.0 хувь, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 407 хүн буюу 19.7 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 761 хүн буюу 11.7 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 67 хүн буюу 1.3 хувиар тус тус буурсан нь нөлөөлөв.

Манай улсад 2009 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирусын халдварын 1240 тохиолдол бүртгэгдсэнээс 811 буюу 65.4 хувь нь Улаанбаатар хотод, 429 тохиолдол буюу 34.5 хувь нь хөдөө орон нутагт гарснаас Өвөрхангай аймагт 62 буюу 5.0 хувь, Дархан-Уул аймагт 36 буюу 2.9 хувь, Сэлэнгэ аймагт 35 буюу 2.8 хувь, Орхон аймагт 33 буюу 2.7 хувь, Дорноговь аймагт 28 буюу 2.3 хувь, Хөвд аймагт 27

The share of female students to the total students was 52.1, in kindergartens 50.3 in general educational schools 50.3 in technical and vocational schools 47.0 and in universities and colleges 60.4. Sex ratio in all types of educational institutions was 50.6, in kindergartens 50.4 in general educational schools 50.6 in technical and vocational schools 47.0 and in universities and colleges 60.7.

In 2009, number of insurers was 556.6 thous.persons, 63.3 percent or 352.1 thousand insurers from total were employees of establishments and 36.7 percent or 204.5 thousand insurers were government institutions' employees.

Through the social insurance fund, 333.8 bln.tug allocated for pension. 72.0 percent of total allocated pension was for elderly, 13.4 percent was pension for disabled persons, 8.0 percent was pension for persons who lost foster and 6.6 percent was pension for military.

In 2009, 1.4 million people received pensions, benefits and assistances with the total amount of 120.1 bln.tug. The number of social welfare service receivers has been increased by 7.5 thousand people or 0.6 percent, the total amount of the allocated fund by 5.4 bln.tug or 4.7 percent in compared with the previous year.

As of the 2009, the number of infectious diseases was 38.9 thous and showing a decrease of 4934 cases or 11.3 percent compared to the 2008. The number of persons infected by shigellosis an increased by 746 persons or 31.7 percent, and gonococcal infection by 209 persons or 3.4 percent. While, the number of persons infected by viral hepatitis, varicella, trichomoniasis and syphilis declined by 3539 persons or 34.0 percent, by 407 persons or 19.7 percent, by 761 persons or 11.7 percent, and by 67 persons 1.3 percent, respectively.

As of 31st of December, 2009, total 1240 persons infected by pandemic (H1N1) and 811 or 65.4 percent out of them recorded at the Ulaanbaatar city and remain 429 persons or 34.5 percent was recorded in 21 aimags. Out of total recorded pandemic (H1N1) cases in aimags, several aimags have recorded higher prevalence of pandemic (H1N1), namely, 62 persons or 5.0 percent recorded in Uvurkhangai, 36 persons or 2.9 percent are in Darkhan-Uul, 35 persons

буюу 2.2 хувь, Говьсүмбэр аймагт 25 буюу 2.0 хувь, Завхан, Дорнод аймагт тус бүр 23 буюу 1.9 хувь, Дундговь, Төв аймагт тус бүр 19 буюу 1.5 хувь, Увс аймагт 17 буюу 1.4 хувь, Баян-Өлгий аймагт 16 буюу 1.3 хувь байна. Энэхүү вирусын халдвараар нийтдээ 28 хүн нас барснаас 5 нь жирэмсэн эмэгтэй байна.

Улсын хэмжээнд 2009 онд 20373 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 331 хэргээр буюу 1.6 хувиар буурчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос буурахад нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргүүд 6.7-12.5 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

or 2.8 percent are in Selenge, 33 persons or 2.7 percent are in Orkhon, 28 persons or 2.3 percent are in Dornogovi, 27 persons or 2.2 percent are in Khovd, 25 persons or 2.0 percent in Govisumber, 23 persons or 1.9 percent are in Zavkhan and Dornod, and 19 persons or 1.5 percent are in Dundgovi and Tuv, 17 persons or 1.4 percent are in Uvs and 16 persons or 1.3 percent recorded in Bayan-Ulgii aimag respectively. Totally 28 persons were died due to this virus, and 5 of them were pregnant mothers.

The total number of crimes committed in 2009 was 20373, reflecting a decrease of 331 crimes or 1.6 percent compared with the same period of the previous year.

The decrease in the number of crimes recorded at the Police Office was mainly due to 6.7-12.5 percent decrease in crimes such as crime against social safety, crime against ownership right, and crime against child, family and social morality.

II. Макро эдийн засгийн үзүүлэлт

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 6055.8 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3564.3 тэрбум төг болж, өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр 0.6 хувиар өсч, зэрэгцүүлэх үнээр 1.6 хувиар буурч байна.

ДНБ-ий (зэрэгцүүлэх үнээр) 1.6 хувийн бууралтад өмнөх оныхоос бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 26.6 хувь, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарынх 20.4 хувь, барилгын салбарынх 48.8 хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний татварын нийт хэмжээ 16.6 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөллөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын дүнгээр 2009 оны жилийн эцэст өмнөх 11 дүгээр сарынхтай харьцуулахад 0.7 хувь, өмнөх оны жилийн эцсийнхээс 4.2 хувиар тус тус өслөө. Бүх бүлгийн үнэ дүнгээрээ 0.4-20.2 хувь нэмэгдсэн нь хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын дүнгээр өмнөх оны жилийн эцсийнхээс 4.2 хувь өсөхөд нөлөөлжээ.

Монголбанкны мэдээгээр мөнгөний нийлүүлэлт (M2) 2009 оны эцэст 2880.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сарынхаас 164.8 тэрбум төг буюу 6.1 хувиар, 2008 оны

II. Macro economical indicators

The preliminary GDP of 2009 reached 6055.8 bln.togrogs at current prices and 3564.3 bln.togrogs at 2005 constant prices. It shows an increase by 0.6 percent at current prices and a decrease by 1.6 percent at 2005 constant prices compared with the previous year.

This decline was mainly due to decrease of value added of wholesale & retail trade by 26.6 percent, financial intermediation by 20.4 percent, construction by 48.8 percent, and net taxes on production by 16.6 percent respectively, compared with previous year.

The national consumer price index in the end of 2009 increased by 0.7 percent and by 4.2 percent compared with the previous month and the end of previous year, respectively. All price group increased by 0.4-20.2 percent, which resulted in the 4.2 percent increase in the overall index compared to the end of previous year.

According to the report of the Bank of Mongolia, money supply (broad money or M2) at the end of 2009, expanded to 2880.0 bln.togrogs, which reflects an increase of 164.8 bln.togrogs or 6.1 percent, over

12 дугаар сарынхтай харьцуулахад 610.0 тэрбум төг буюу 26.9 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2009 оны 12 дугаар сарын эцэст 371.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 7.9 тэрбум төг буюу 2.2 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 35.4 тэрбум төг буюу 8.7 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны 12 дугаар сарын эцэст 2655.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 23.0 тэрбум төг буюу 0.9 хувь, өмнөх оны 12 дугаар сарынхаас 19.4 тэрбум төг буюу 0.7 хувиар тус тус өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны 12 дугаар сарын эцэст 121.7 тэрбум төг болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.6 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх сарынхаас 44.7 тэрбум төг буюу 26.9 хувиар буурч, харин өмнөх оны 12 дугаар сарынхаас 28.4 тэрбум төг буюу 1.3 дахин нэмэгджээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 462.0 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 17.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 5.9 тэрбум төг буюу 1.3 хувь, өмнөх оны 12 дугаар сарынхаас 273.3 тэрбум төг буюу 2.4 дахин тус тус нэмэгдсэн байна.

Үнэт цаасны арилжаа 2009 онд 255 удаа явагдаж, 23.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 89.9 сая.ш үнэт цаас арилжаалжээ.

Арилжигдсан үнэт цаасны тоо 2009 онд өмнөх оныхоос 80.3 сая.ш буюу 47.2 хувиар, гүйлгээний хэмжээ 39.2 тэрбум төг буюу 62.8 хувиар тус тус буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн нийт хэмжээ 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1993.0 тэрбум төг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2321.6 тэрбум төг болж, нийт тэнцэл 328.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн алдагдал өмнөх оныхоос 32.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд төсвийн орлогын бууралт зардлынхаас 2.3 пунктээр өндөр байгаа нь нөлөөлжээ.

Төсвийн урсгал орлого 1965.5 тэрбум төг, урсгал зардал 1792.1 тэрбум төг болж, урсгал тэнцэл 173.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

November 2009 and an increase of 610.0 bln.togrogs, or 26.9 percent, compared to December 2008.

At the end of December 2009, currency issued in circulation reached 371.8 bln.togrogs demonstrating an increase of 7.9 bln.togrogs, or 2.2 percent compared to November 2009, and a decrease of 35.4 bln.togrogs, or 8.7 percent compared to December 2008.

Loans outstanding at the end of December 2009, amounted to 2655.0 bln.togrogs, an increase of 23.0 bln.togrogs, or 0.9 percent over the November 2009, and of 19.4 bln.togrogs, or 0.7 percent, compared to December 2008.

Meanwhile, principals in arrears decreased by 44.7 bln.togrogs or 26.9 percent over the November of 2009, reaching 121.7 bln.togrogs which was 4.6 percent of total loans outstanding and increased by 28.4 bln.togrogs or 1.3 times compared to December of 2008.

The non-performing loans reached 462.0 bln.togrogs, which was 17.4 percent of the total loans outstanding and it is increased by 5.9 bln.togrogs or 1.3 percent over the November of 2009, and by 273.3 bln.togrogs or 2.4 times compared with December of 2008.

In 2009, there were 255 trading days and 89.9 mln.shares valued at 23.2 bln.togrogs were traded.

The number of shares traded decreased by 80.3 mln.stocks or 47.2 percent and the value of traded stocks by 39.2 bln.togrogs or 62.8 percent compared to the previous year respectively.

As of the preliminary result of 2009, total revenue and grants of General Government budget amounted to 1993.0 bln.togrogs and total expenditure and net lending was 2321.6 bln.togrogs representing a deficit of 328.6 bln.togrogs in the General Government budget overall balance. The higher deficit by 32.2 bln.togrogs against the previous year was due to total revenue decline which was by 2.3 point higher than the total expenditure decline.

Current revenue of General Government amounted to 1965.5 bln.togrogs and current expenditure reached 1792.1 bln.togrogs. Thus, the budget current balance was in surplus of 173.4 bln.togrogs.

Татварын нийт орлого өмнөх оныхоос 275.6 тэрбум төг буюу 14.6 хувиар буурахад зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 198.3 тэрбум төг буюу 51.1 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварынх 47.9 тэрбум төг буюу 18.9 хувь, нэмэгдсэн өртгийн албан татварынх 42.2 тэрбум төг буюу 11.5 хувь, онцгой албан татварынх 11.7 тэрбум төг буюу 6.6 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оныхоос 90.1 тэрбум төг буюу 34.6 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 75.5 тэрбум төг буюу 3.3 дахин, навигацийн орлого 11.5 тэрбум төг буюу 60.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2321.6 тэрбум төг болж, өмнөх оныхоос 145.2 тэрбум төг буюу 5.9 хувиар буурчээ. Үүнд цалин, хөлсний зардал 34.4 тэрбум төг буюу 6.3 хувь, татаас, шилжүүлэг 107.2 тэрбум төг буюу 15.6 хувиар өссөн хэдий ч бараа, үйлчилгээний бусад зардал 119.8 тэрбум төг буюу 23.5 хувь, хөрөнгийн зардал 166.5 тэрбум төг буюу 26.7 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зардал 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 457.9 тэрбум төг болж, өмнөх оныхоос 166.5 тэрбум төг буюу 26.7 хувиар буурчээ. Хөрөнгийн зардлын бууралт нь дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгө оруулалт 91.5 тэрбум төг буюу 19.2 хувь, улсын нөөц бүрдүүлэх зардал 67.1 тэрбум төг буюу 76.6 хувиар багассанаас голлон шалтгаалжээ.

Манай улс 2009 онд дэлхийн 118 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 4033.9 сая ам.доллар, үүнээс экспорт 1902.6 сая ам.доллар, импорт 2131.3 сая ам.доллар боллоо.

Гадаад худалдааны тэнцэл 2009 онд 228.7 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оныхоос 481.3 сая ам.доллар буюу 3.1 дахин багасчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 1745.1 сая ам.доллар буюу 30.2 хувь, үүний дотор экспортын хэмжээ 631.9 сая ам.доллар буюу 24.9 хувь, импортын хэмжээ 1113.3 сая ам.доллар буюу 34.3 хувиар тус тус буурчээ.

Compared with the previous year, tax revenue declined by 275.6 bln.togrogs or 14.6 percent. This was mainly due to decreases of 198.3 bln.togrogs or 51.1 percent in price increase tax of some products, of 47.9 bln.togrogs or 18.9 percent in corporate income tax, of 42.2 bln.togrogs or 11.5 percent in value added tax, and of 11.7 bln.togrogs or 6.6 percent in excise taxes.

Compared with the previous year, non-tax revenue increased by 90.1 bln.togrogs or 34.6 percent, out of which dividends went up by 75.5 bln.togrogs or 3.3 times, revenue from navigation by 11.5 bln.togrogs or 60.1 percent respectively.

Compared with the previous year, total expenditure and net lending of the General Government budget reached 2321.6 bln.togrogs reflecting the decrease of 145.2 bln.togrogs and 5.9 percent. This was mainly due to declines of 34.4 bln.togrogs or 6.3 percent in wages and salaries and 107.2 bln.togrogs or 15.6 percent in subsidies and transfers, although decreases of 119.8 bln.togrogs or 23.5 percent in other goods&services expenses and, of 166.5 bln.togrogs or 26.7 percent in capital expenditure.

Spending of 457.9 bln.togrogs on capital expenditure as of the preliminary result of 2009 was lower by 166.5 bln.togrogs or 26.7 percent over the of previous year. Decrease in capital expenditure was due to a decline of 91.5 bln.togrogs, or 19.2 percent in domestic investment of internal sources and of 67.1 bln.togrogs, or 76.6 percent in acquisition of stock.

As of the 2009, Mongolia traded with 118 countries from all over the world and total external trade turnover reached 4033.9 mln.US dollars, of which exports made up 1902.6 mln.US dollars and import did 2131.3 mln.US dollars.

External trade balance in 2009, showed a deficit of 228.7 mln.US dollars, by 481.3 mln.US dollars or 3.1 times decrease compared with the previous year.

Compared with the previous year, total external trade turnover declined by 1745.1 mln.US dollars, or 30.2 percent, of which exports by 631.9 mln.US dollars, or 24.9 percent, imports by 1113.3 mln.US dollars, or 34.3 percent respectively.

Нийт экспортын хэмжээ өмнөх оныхоос буурахад зэсийн баяжмал үнийн дүнгээрээ 39.9 хувь, цайрын баяжмал үнийн дүнгээрээ 20.8 хувь, боловсруулаагүй алтны биет хэмжээ 47.1 хувь болон үнийн дүнгээрээ 44.0 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Compared with the same period of the previous year, total export fell due to declines of 39.9 percent in value of copper concentrate; and of 20.8 percent in value of zinc concentrate; and of 47.1 percent in volume and 44.0 percent in value of gold, in unwrought or semi-manufactured forms, respectively.

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

III. Economical sector indicators

Улсын хэмжээгээр 2009 онд 44.0 сая толгой мал, үүний дотор 277.1 мянган тэмээ, 2221.3 мянган адуу, 2599.3 мянган үхэр, 19274.7 мянган хонь, 19651.5 мянган ямаа тоологдов.

According to the results of the 2009 livestock census 44.0 mln. livestock was counted, of which 277.1 thous. camel, 2221.3 thous. horse, 2599.3 thous. cattle, 19274.7 thous. sheeps and 19651.5 thous. goat.

Малын нийт тоо өмнөх оныхоос 1.7 хувь буюу 735.5 мянган толгойгоор нэмэгдсэний дотор тэмээ 10.7 мянга буюу 4.0 хувь, адуу 34.4 мянга буюу 1.6 хувь, үхэр 95.9 мянга буюу 3.8 хувь, хонь 912.4 мянга буюу 5.0 хувиар өсч, харин ямаа 317.9 мянга буюу 1.6 хувиар буурчээ.

The total number of livestock increased by 1.7 percent or 735.5 thous. heads compared with the previous year, of which camel by 4.0 percent or 10.7 thous., horse by 1.6 percent or 34.4 thous., cattle by 3.8 percent or 95.9 thous., sheep by 5.0 percent or 912.4 thous increased, but goat decreased by 1.6 percent or 317.9 thous.

Улсын хэмжээгээр 2009 оны байдлаар оны эхний малын 4.0 хувьтай тэнцэх 1732.9 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оныхоос 92.3 мянгаар буюу 5.6 хувиар их байна. Хорогдсон малын 90.0 хувийг бог мал, 10.0 хувийг бод мал эзэлж байна.

As of the 2009, 1732.9 thousand adult animals have been lost it is equals to 4.0 percent of total livestock at the beginning of the year. Compared with the previous year, the number of losses of adult animals increased by 92.3 thousand heads or 5.6 percent. Out of losses of adult animals, 90.0 percent were the camels, cattles and horses and 10.0 percent were the goats and sheeps.

Улсын хэмжээгээр 2009 онд 391.7 мян.т үр тариа, 151.2 мян.т төмс, 78.0 мян.т хүнсний ногоо хурааж, 893.4 мян.т өвс, хадлан бэлтгэжээ. Өмнөх оныхоос хураасан үр тариа 178.8 мян.т буюу 84.0 хувь, төмс 16.4 мян.т буюу 12.2 хувиар өсч, харин хүнсний ногоо 0.6 мян.т буюу 0.7 хувь, өвс 137.5 мян.т буюу 13.3 хувь, гар тэжээл 11.3 мян.т буюу 32.8 хувиар бага бэлтгэжээ.

As of the 2009, were harvested total amount of 391.7 thous. tons cereals, 151.2 thous. tons potatoes, 78.0 thous. tons vegetables and prepared 893.4 thous. tons hay harvest. Compared with the previous year, volume of cereals, potatoes were increased by 178.8 thous. tons or 84.0 percent, 16.4 thous. tons or 12.2 percent, but volume of vegetables, hay harvest and fodder were decreased 0.6 thous. tons or 0.7 percent, 137.5 thous. tons or 13.3 percent and 11.3 thous. tons or 32.8 percent respectively.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2009 онд (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 1704.7 тэрбум төг болж, өмнөх оныхоос 58.1 тэрбум төг буюу 3.3 хувиар буурлаа. Энэхүү бууралтад боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 83.3 тэрбум төг буюу 14.2 хувь, металлын хүдэр олборлолтын дэд салбарынх 48.9

As of the 2009, the total industrial output reached 1704.7 bln. togrogs demonstrating a decrease of 3.3 percent or by 58.1 bln. togrogs (at 2005 constant prices), compared with the pervious year. The fall in the industrial output was due to a decrease of 83.3 bln. togrogs or 14.2 percent in manufacturing sector output and of 48.9

тэрбум төг буюу 6.2 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт өмнөх оныхоос буурахад төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жоншны баяжмал, алт, гянтболдын баяжмал зэрэг уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.6-72.8 хувиар багассан нь нөлөөлжээ.

Нарийн боов, катодын зэс, амтат ус, ундаа, хиам, самнасан ноолуур, талх, цемент, тамхи, шохой, хивс, металл бэлдэц, спирт, металл цувимал, бетон зуурмаг, цул бетон, төмөр бетон эдлэл, молибдений исэл зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.6-92.6 хувиар буурсан нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн 14.2 хувийн бууралтад голлон нөлөөлсөн байна.

Улсын хэмжээнд 2009 онд нийт 279.4 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 89.7 хувь буюу 250.6 тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллагууд, 10.3 хувь буюу 28.8 тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллагууд гүйцэтгэв.

Бүх төрлийн тээврээр 2009 онд 24.7 сая тонн ачаа, давхардсан тоогоор 232.4 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос тээвэрлэсэн ачаа 825.3 мян.т буюу 3.5 хувь, зорчигчдын тоо 0.8 сая хүн буюу 0.3 хувиар тус тус өсчээ.

Бүх төрлийн тээврээр тээсэн ачааны өсөлтөд өмнөх оныхоос авто тээврээр тээсэн ачаа 1.3 сая.т буюу 14.1 хувиар өссөн нь нөлөөлжээ. Өмнөх онтой харьцуулахад авто тээврээр зорчигчид 2.1 сая хүнээр нэмэгдэж, харин төмөр замынх 1.3 сая хүн, агаарын тээврийнх 56.4 мянган хүнээр тус тус буурчээ.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр 2009 оны 12 дугаар сард хамгийн их тунадас (15.9 мм) Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд орсон байна. Энэ сарын агаарын хамгийн их температур Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 6.3 хэм дулаан, хамгийн бага температур Завхан аймгийн Тосонцэнгэл суманд -46.3 хэм хүйтэн, цасан бүрхүүлийн хамгийн их зузаан Архангай аймгийн Төвшрүүлэх суманд 40 см байжээ. Салхины хамгийн их хурд Дундговь аймгийн Мандалговь суманд 40 м/сек хүрсэн байна.

bln.togrogs or 6.2 percent in mining of metal ores division output.

Compared with the previous year, the output of the mining and quarrying sector was decreased mainly due to the 0.6-72.8 percent reduction in output of main mining products such as iron ore, zincum concentrate, fluor spar concentrate, gold and tangsten concentrate.

At the same time, 14.2 percent decrease in output of manufacturing sector was mainly due to the 2.6-92.6 percent reduction in output of products such as bakery products, copper, soft drinks, sausage, combed down, breads, cement, cigarettes, lime, carpet, metal steel, spirit, metal foundries, concentrate mortar, solid concentrate, articles of iron concrete and molybdenum concentrate.

As of the 2009, construction and installation work worth 279.4 bln.togrogs were carried out. Of which 250.6 bln.togrogs or 89.7 percent were executed by domestic entities, and 28.8 bln.togrogs or 10.6 percent by foreign entities.

As of the 2009, 24.7 mln.ton freight and 232.4 mln.passenger (duplicated) were carried by all types of transport. Compared with the same period of the previous year, carried freight rose by 3.5 percent or 825.3 thous.ton, and carried passengers by 0.3 percent or 0.8 mln.persons.

The growth in the volume of freight was due to an increase of 1.3 mln.ton, or 14.1 percent, in freight carried by the auto transport compared to the previous year. Compared to the previous year, passengers carried by auto transport increased by 2.1 mln.persons, while those carried by railway and air transport decreased by 1.3 mln.persons and by 56.4 thous.persons respectively.

Institute of Meteorology and Hydrology reveals that maximum precipitation was (15.9 mm) in Tsagaandelger soum of Dundgovi aimag. Absolute high air temperature reached 6.3°C in Dalanzadgad soum of Umnugovi aimag, whereas absolute low air temperature was -46.3°C in Tosontsengel soum of Zavkhan aimag. Highest cover of snow was 40 cm in Tovshruuleh soum of Arkhangai aimag. Maximum wind speed reached 40 m/sec in Mandalgovi soum of Dundgovi aimag in December, 2009.

Хүхэрлэг хийн агууламж 2009 оны 12 дугаар сард Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг орчимд 30 удаа, 1-р хороолол орчимд 20 удаа, 13-р хороолол орчимд 30 удаа, 32-ын тойрог орчимд 19 удаа, Офицеруудын ордон орчимд 28 удаа, азотын давхар ислийн агууламж Баруун 4 зам орчимд 18 удаа, 1-р хороолол орчимд 9 удаа, 13-р хороолол орчимд 22 удаа, 32-ын тойрог орчимд 16 удаа, Офицеруудын ордон орчимд 12 удаа, 10 микрон хүртэлх тоосны агууламж Хан-Уул дүүрэг орчимд 9 удаа, Баруун 4 зам орчимд 8 удаа, 1-р хороолол орчимд 27 удаа, 13-р хороолол орчимд 26 удаа, Дархан-Уул аймгийн Дархан суманд 26 удаа, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж 1-р хороолол орчимд 2 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын мэдээгээр аюулт үзэгдэл, осол 2009 онд 2460 удаа гарчээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 9.8 тэрбум төгрөгийн хохирол учирч, 248 хүн амь насаа алдаж, 990 гэр, орон сууц шатаж, 334.3 мянган мал хорогдсон байна. Аюулт үзэгдэл, ослыг төрлөөр нь авч үзвэл ой, хээрийн түймэр 120 удаа, объектын түймэр 2165 удаа, хүчтэй салхи, шуурга, хүйтэн бороо 15 удаа, аадар бороо, үер 10 удаа, боом өвчний 18 тохиолдол гарчээ.

Concentration of sulphur dioxide exceeded from the maximum allowable concentration of air quality standard by 30 times around the Khan-Uul district, 20 times around the 1st micro district, 30 times around the 13th micro district, 19 times around the 32nd Toirog and 28 times around the Offitseruudiin ordon; nitrogen dioxide exceeded by 18 times around the west crossroad, 9 times around the 1st micro district, 22 times around the 13th micro district, 16 times around the 32nd Toirog and 12 times around the Offitseruudiin ordon; particulate matter less than ten micrograms exceeded by 9 times around the Khan-uul district, 8 times around the west crossroad, 27 times around the 1st micro district, 26 times around the 13th micro district in the Ulaanbaatar city. Also, particulate matter less than ten micrograms exceeded by 26 times in Darkhan soum of Darkhan-Uul aimag; carbon dioxide exceeded 2 times around the 1st micro district in December, 2009.

National emergency and management agency reveals that there were 2460 disasters in 2009. Damage of disasters amount was 9.8 bln.togrogs, 248 people died, 990 dwellings have burnt fire and 334.3 thousand livestock had lost. By the types of disasters, there were 120 times forest fires, 2165 times object fires, 15 strong storm, 10 thunderstorm and flood, 18 of anthrax have registered.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

С.МЭНДСАЙХАН

